

Эхээс чухал хэсгийг олж,
үндэслэлийг нь тайлбарлах, аян
замын тэмдэглэлд шинэ
мэдээлэл оруулж бичих



Гэрийн даалгавраа ярилцъя

- Газар дэлхий мөнгөн сор сууж, бууралтана.
- Гадаа дун цагаан цас малгайлан орно.
- Байгаль дэлхий цаанаа нэг гэрэлтсэн өнгөлөг, тунгалаг.
- Цаанаа л нэг цэлмэг тэнгэр шиг саруулхан.
- Алтан нарыг хэн ч үл өгүүлнэ.
- Гэнэт цасны үнэртэй, зөөлөн салхи сэвэлзэнэ.
- Хөвөн мэт шинэхэн цас хөвсөлзөнө.
- Хөгжилдөн наадах мэт цас бургина.
- Сүү шиг цагаахан сэтгэл нэг л баясгалантай.



Эхээс дүрслэлийг ялгаж бичье. \ адилтгал, ихэсгэл, багасгал, амьдчилал\
Дүрслэлээс ашиглан байгалийн сайхныг төсөөлөн зураглаж бичье.

“НАМАР АЙ” - эхээс

- ✦ Хөх хяруу хорголтсон зүс буурал өглөө
- ✦ Ар хэцийн цас мөстөж, талстлаад сондоршино.
- ✦ Алтан шарыг тунаруулсан уясуу өнгөөр уулс дүнсийнэ.
- ✦ Шанд булгийн усан хүйтэн болроор тунгалагшина.
- ✦ Сайр дэвсгийн бэл дэх урсаа толь мэт үзэгдэнэ.
- ✦ Тугалын улаан хаданд тошлог иш дээрээ иснэ.
- ✦ Тасхийж дуу цуурайлахад бөмбөрч унана.
- ✦ Царам хярын хэжмэгээр цасан хяруут цагаан салхи исгэрнэ.
- ✦ Уулс мөнгөн бронз мэт тунгалаг ширхгээр битүү түрхүүлж, усны зах цайртан хөлдөнө.
- ✦ Сонгины цооргоно хөөмийлж исгэрнэ.
- ✦ Хаяа хөвөөний нь зэгс шагшуурга халиу суусрын сор шиг гэрэлтэнэ.
- ✦ Хар усан нуур бадамлянхуан орон шүү лээ, хар л даа, энэ байна гэх шиг бөлбөөн дэлбээ цагаан шараар давалгаална.
- ✦ Сээрийн толгод эзэгийтэн ягаарна.
- ✦ Үдшийн хүүш сүүдэр өрөм загсахаас урьтаж анина.
- ✦ Шилэвч, Дэлбээний ар шижир шараар алтарна.
- ✦ Цахир, Цалгайн нуруу цагаан хашаар цэгээнтэнэ.
- ✦ Гол дагасан ногоон зүлэг өдөр өдрөөр хумигдана.
- ✦ Голдиролдоо эгшсэн усыг аргадан аргадах мэт харагдана.
- ✦ Ус гол урссаар боловч умрын салхинаа зайртана.
- ✦ Өвсөн шилбэ дагаж өглөөний хяруу нулимстана.
- ✦ Дунд булгийн халгай лууль дун цагаанаар мөнгөлөгтжээ.



(Б.Золбаяр)

- Алтан шарыг тунаруулсан уясуу өнгөөр уулс дүнсийнэ.
- Сайр дэвсгийн бэл дэх урсаа толь мэт үзэгдэнэ.
- Царам хярын хэжмэгээр цасан хяруут цагаан салхи исгэрнэ.
- Уулс мөнгөн бронз мэт тунгалаг ширхэгээр битүү түрхүүлж, усны зах цайртан хөлдөнө.
- Сонгины цооргоно хөөмийлж исгэрнэ.
- Хаяа хөвөөний нь зэгс шагшуурга халиу суусрын сор шиг гэрэлтэнэ.
- Хар ус нуур бадамлянхуан орон шүү дээ, хар л даа энэ байна гэх шиг бөлбөөн дэлбээ цагаан шараар давалгаална.
- Голдиролдоо эгшсэн усыг аргадан аргадах мэт харагдана.
- Өвсөн шилбэ дагаж өглөөний хяруу нулимстана.



“Эквадорт хийсэн тэмдэглэл”, “Алтай” хоёр эхээс олж авсан шинэ мэдээллээ жагсааж бичээрэй.

Эквадорт хийсэн тэмдэглэл

- Эквадорын Имбабура муж
- Инка хүний дүр төрх, хувцаслалт, амьдарч буй газар орны ,байдал, амьдрал
- Инка буюу индейчүүд мөхлийн ирмэгт ойрхон ирээд, 1823 онд маршал Сүкрегийн удирдсан зэвсэгт тэмцлийн ачаар аврагдсан тухай

Алтай

- Баруун алтайн байгалийн сайхан
- Алтай сүрлэг сайхан уулс, гол усны дүр зураг, байр байдал
- Эх орноо хайрлах сэтгэл



Эквадорт хийсэн тэмдэглэл”, “Алтайд” эхийг аян замын тэмдэглэл болохыг батлах чухал хэсгийг олж, үндэслэлийг нь тайлбарлаарай.

Эквадорт хийсэн тэмдэглэл

- Газар орны нэр тодорхой
- Эхлэл хэсэг буюу аялсан газрын байгалийн байдал, орчин нөхцөлийн дүрслэл
- Гол хэсэг буюу хүмүүсийн аж амьдрал, соёл
- Уран дүрслэл, хэлц, зохиогчийн мэдрэмж сэтгэгдэл, үзэл бодол
- Сонирхолтой шинэ мэдээлэлтэй.

Алтайд

- Аялсан газрын нэр
- Алтай нутгийн суурин, уулс, оргил, хөндий, униар будан, салхий, амьсгал мод ургамал зэрэг байгалийг нүдэнд үзэгдэж, сэтгэлд буутал дүрслэлсэн үг хэллэг, дүрслэлүүд
- Зохиогчийн мэдрэмж сэтгэгдэл
- Шинэ мэдээлэл

Аян замын тэмдэглэл

- ✓ Аялсан газар нутаг, байгалийн байдал, хүмүүсийн аж амьдрал, зан заншил, соёл үзэл бодол зэргийг уншигчдад сонирхуулах, танин мэдүүлэх зорилгоор бичсэн тэмдэглэлийг аян замын тэмдэглэл гэдэг.
- ✓ Аяллын тухай сонин содон үг хэллэг, уран дүрслэл, хэлц ашиглан, уншигчдын сэтгэлд бууж, нүдэнд харагдтал бичсэнээр тэднийг шинэ сонин аян замд хөтөлнө.

Яаж бичих вэ?

- ✓ Аялсан он, сар өдөр, газар орны нэрийг тодорхой бичнэ.
- ✓ Тохиолдсон бүхнээс хамгийн чухал, сонирхолтой гэж үзсэн зүйлээ сонгож бичнэ.
- ✓ Уншигчдад хэрэгтэй шинэ содон зүйлийг оруулж бичнэ.
- ✓ Үйл явдлын жагсаалт бичихээс зайлсхийх, бүх зүйлийг тайлагнахгүй байх, өөрийн мэдрэмж сэтгэгдлээ бичих
- Эхлэл, гол , төгсгөл хэсэгтэй байна.



Аян замын тэмдэглэлдээ шинэ мэдээлэл оруулж бичье.

Өгөгдсөн шинэ мэдээлэл, үг хэллэгийг дэлгэрүүлж бичнэ.

Найз нөхдөө тухайн газар нутгийг очиж үзэхсэн гэсэн хүсэл сэтгэгдэл төртөл бичнэ.

Ямар бүтэц дараалалтай бичихээ төлөвлөж бодоорой.

ГОВЬ НУТГААР ХАМТ АЯЛЦГААЯ

Хонгорын элс

- + Хонгорын элс нь баруун хойноос зүүн урагш чиглэн 130 гаруй км үргэлжилнэ.
- + Зарим газартаа 20 гаруй км өргөн бөгөөд манай орны хамгийн урт элсэн манхан.
- + Хонгорын элсний хамгийн өндөр хэсгийг Дуут манхан гэх бөгөөд есөн давхар байшингаас ч өндөр аж.
- + Элс нь салхиар нуран гулсахдаа онгоц мэт хүнгэнэн дуугарна.
- + Манхны орой дээр гарахад цааш хэдэн зуун манхан толгод үргэлжлэн харагдана.
- + Хонгорын элсний ойр хавийг бүхэлд нь харахад урдуураа хадтай уул, дундуураа ургамал ургах аргагүй элсэн манхан, хойд бэлээр нь гол урсаж ногоорсон баянбүрд харагдах нь тун үзэсгэлэнтэй.

Нэмэгт уул

- + Үлэг гүрвэлийн олдвороор дэлхийд алдаршсан.
- + Эцэс төгсгөлгүй үргэлжлэх олон хавцлыг харна.
- + Хавцал нь ер бусын үлгэр домгийн ертөнц мэт санагдана.
- + Хананд нь үлэг гүрвэлийн яснууд цухуйн үзэгдэнэ.
- + Он цагийн аясаар элэгдсэн хананууд нь янз бүрийн цонх, тагттай байшинг санагдуулахаар харагдана.
- + Нэмэгт уулыг "лууны булш" гэж эрдэмтэд нэрлэх нь бий.

Монгол орны буурал түүхийг агуулсан байгалийн үзэсгэлэнт говь нутгийг нүдээр үзэж, сэтгэлээр мэдрэхээр хүлгийн жолоо залав.

Өглөөний нарны туяа элсний өнгийг улам тодруулан гялтгануулна.

Салхиар зурагдсан элсэн хээ уран зургийг санагдуулна.

Тэмээдийг харахад говийн жинхэнэ дүр төрх гэж энэ л болов уу гэлтэй.

Элсний нарийн ширхэг, шаргалтсан тослог өнгө нь сэтгэл булаана.

Хөл нүцгэнээр элсэн дээгүүр алхахад...

Зэрэглээ хөвсөн говьд царцаа дэвхрэг нь шаргина. Тооройн сүүдэрт ботго буйлна. Их манхан тэнгэр говьд уусан алдарна.

Хүн байтугай амьтны ч бараагүй хадат ян, өргөн хөндий, цэлийсэн хоолой, гөлийсөн тойром, зэрэм тал зэрэг аялагчдын сонирхлыг эрхгүй татсан дагшин нутаг.

Говь гэмээнэ говь билээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

